



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.5, 7.1.6, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.3.2, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.11, Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалаар батлагдсан Ерөнхий гэрээ байгуулах журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий гэрээгээр худалдан авах урвалж, оношлуур, хэрэгслийн жагсаалтыг боловсруулан, Мэргэжлийн байгууллагад саналыг хүргүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Ерөнхий гэрээгээр худалдан авах урвалж, оношлуур, хэрэгслийн жагсаалтыг боловсруулах үйл ажиллагааг холбогдох дүрэм, журмын дагуу шуурхай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Г.Цэцэнсанаа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА  Д.НАРАНТУЯА

1422 010158